

БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ЗАРИМ САНАА

Ш.Ичинхорлоо, профессор, БоСС

Abstract: This article expresses that the Educational policy, which supports the human development of Mongolian. This questionnaire (120 students from 6 public and private universities) showed the importance of right formation, communication skill, self sustainable and ethics. The Educational policy proposed the connected proposals about the Educational purpose, content, teacher, learners, teaching technology and evaluation. In particular, The policy of the Educational, which contents the national culture and tradition of Mongolia and focused on the need of Social group, develops the learners' talent and ability and implements the curriculums of elective learning subjects content, closed in the world level of Education.

Түлхүүр үг: Боловсролын бодлого, монгол хүний хөгжил, боловсролын зорилго, боловсролын агуулга, багш, оюутан.

Удиртгал

Тус илтгэлд боловсролын бодлоготой холбоотой зарим суурь асуудлыг авч үзэх болно. Учир нь сүүлийн жилүүдэд боловсролын талаар баримтлах 1995 онд баталсан бодлого үндсэндээ цаг үеэ өнгөрөөж, шинэ нөхцөлд тохирох бодлого үгүйлэгдэх болсон. Боловсролыг тууштай хөгжүүлж, чанарыг дээшлүүлэхийн тулд урт, дунд хугацааны боловсролын бодлого боловсруулах шаардлагатай боллоо.

Энэ илтгэлийн зорилт бол боловсролын бодлого гэдэг юу болох, орчин үед боловсролын бодлого ямар байх, түүний агуулгад юу багтах талаар судалгаанд үндэслэн зарим санаа бодлыг дэвшүүлж олон нийтийн хүртээл болгохыг зорилоо.

Тус илтгэлийг бичихэд энэ чиглэлийн баримт бичиг ном зохиол судлах, оюутнуудаас асуулга авах, мэдээлэлд анализ хийх, шинэ мэдлэг бүтээх зэрэг аргыг хэрэглэсэн.

Судалгаа, үр дүн

Бодлого гэдэг юу вэ?

Аливаа улсын төр засаг өөрийн орны хөгжлийн түвшин, нийгэм эдийн засгийн

тогтолцоо, харилцаанд зохицуулан хүн арддаа тодорхой түвшний боловсролыг яаж чанартай олгох болон түүнийгээ хэрэгжүүлэх үүднээс үзэл баримтлал, зарчим, арга замын ерөнхий бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг.


Аливаа бодлого ямагт ирээдүй рүү чиглэсэн байна. Ирээдүй гэдгийн цаана улс орны хэтийн төлөв, хүүхэд залуус нийт ард иргэдийн ирээдүй байна.

Бодлого /policy/ гэдэг бол томоохон хэмжээний асуудлуудыг алс хэтдээ шийдвэрлэхэд чиглэсэн үзэл, санаа, зарчим, хандлага, зорилт, шийдвэр, арга хэмжээ зэргийг багтаасан цогц зүйл /4,61/.

Бодлого нь ямагт урт удаан хугацаанд чиглэсэн үзэл, санаа, асуудалд, арга хэмжээ зэрэг байдаг /6, 9/. Бодлого нь нийгмийн томоохон асуудлыг цогц байдлаар хамрахын хамт салбарын, бүс нутгийн гэх мэт байна. Жишээлбэл, Улаанбаатар хотын сургуулийн өмнөх насны хүүхдийн 80%-ийг цэцэрлэгт хамруулах, улсын хэмжээнд боловсролын чанарыг сайжруулах гэх мэт.

Бодлого нь: 1/ үндсэн асуудал, 2/ түүний шалтгаан, судалгаа, 3/ шийдэл, шийдвэр, үндэслэл, 4/ авах арга хэмжээ, төлөвлөгөө, 5/ гарах үр дагавар /ээрэг, сөрөг/ зэрэг зүйлээс бүрдэнэ.

Бүдүүвч №1



Боловсролын бодлогын тухай

Боловсролын бодлого нь 1/үнэн бодит мэдээлэлд түшиглэсэн, 2/ үр дүнд суурилсан, 3/

стратеги зорилгод хүрэх үйл ажиллагаа, 4/урт хугацааны үр дүнд чиглэсэн байна /"Боловсролын бодлого, төлөвлөлт, удирдлага" ЮНЕСКО-ийн

сургалтын материал. УБ. 2012. Сургалт-семинар. Хичээл №1. Слайд №6. Хуудас 1/.

Боловсролын бодлого нь боловсролын салбарт тулгамдаж буй үндсэн асуудлуудыг алс хэтдээ шийдвэрлэхэд чиглэсэн үзэл, санаа, зарчим, хандлага, зорилт, арга хэмжээ, үр дүн зэргийн нэгдэл.

Өнөөгийн боловсролын салбарт зангилаа ямар асуудлууд байна вэ? гэдгийг судалж илрүүлэх шаардлага юуны түрүүнд гарч ирж байна. Жишээ нь, боловсролын чанар, үр өгөөжийг сайжруулах асуудал нь бодлого болж цаашид шийдэгдэх ёстой зүйлийн нэг мөн. Боловсролын чанарыг сайжруулахын тулд урт /20 жил/, дунд 10 жил/, богино /5 жил/ хугацааны төлөвлөгөө, цогц арга хэмжээ авах шаардлагатай. Тухайлбал, боловсролын бодлогын урт болон дунд хугацааны төлөвлөлтөд бага, дунд боловсролын стандартыг эргэн харж, илүү бодитой, прагматик, сурагч төвтэй, интеграц болгох, багшийн ажлын ачааллыг оновчлох, ажлын үнэлэмжийг дээшлүүлэх, сурагчийн хөгжлийг 1-р зэргийн зорилт болгож, үүнийг дэмжсэн хүүхдэд ээлтэй орчин ЕБС-д бүрдүүлэх, анги дүүргэлтийг хэвийн болгох, монгол соёл, уламжлалыг сургалтын агуулгад тусгах, жишээ нь, ийм чиглэлийн олон хөтөлбөр боловсруулж, сурагчид сонгон судлах гэх мэт арга хэмжээ авах хэрэгтэй болно.

Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлуудыг ул суурьтай судалж, тэдгээрийг бүлэглэн тэргүүлэх асуудлуудыг багцлан тодорхойлох алхмыг энэ салбарын судлаачдын баг хамгийн нэгдүгээрт хийнэ.

Ингэж асуудлуудыг судалж илрүүлэх явцад эдгээр асуудлын шалтгааныг эхлээд судалж илрүүлж байж сая оновчтой шийдвэр гаргах алхам руу орно. Шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь бүрэн, зөв дэс дараатай, цаг хугацааг онож хуваарилахад алдаа гаргаж болохгүй.

Эдгээр арга хэмжээ хэр биелж байгаа талаар тогтмол хяналт шинжилгээ хийж, завсрын үр дагавар /үр дүн/-ыг тогтмол гаргаж, зохих засвар залруулга хийж явах шаардлага мөн байдаг.

Боловсролын салбарт тулгараад байгаа үндсэн /гол/ асуудлуудыг судалж ТОДОРХОЙЛСОН нөхцөлд бодлогын зорилго, зорилтыг тодорхойлох боломжтой.

Бүдүүвч №2

АСУУДАЛ —————> БОДЛОГЫН ЗОРИЛТ

Боловсролын бодлогын дунд хугацааны зарим зорилтыг авч үзвэл: бага, дунд ангийн сурагчдын

хамран сургалтын хувийг дээшлүүлэх, жишээ нь, өнөөдөр Монгол улсад сургуулийн насны 70.000 хүүхэд сургуульд хамрагдахгүй байгаа, боловсролын түвшин болгонд хамрагдсан ядуу өрхийн хүүхдүүд болон охидын харьцаа, бичиг үсэг тайлагдалтын түвшин гэх зэрэг /”Боловсролын бодлого, төлөвлөлт, удирдлага” ЮНЕСКО-ийн сургалтын материал. УБ. 2012. Сургалт-семинар. Сэдэв №5, слайд №6/.

Боловсролын бодлогын урт хугацааны зорилтоос авч үзвэл ядуурлыг бууруулах, амьжиргааны чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх: чанартай хүнс тэжээл, эрүүл мэнд, иргэншил, тэгш байдал руу чиглэнэ /”Боловсролын бодлого, төлөвлөлт, удирдлага” ЮНЕСКО-ийн сургалтын материал. УБ. 2012. Сургалт-семинар. “Боловсролын бодлогын мөчлөг”. Слайд №11. Хуудас 1/.

Орчин үед боловсролын бодлого олон төрлийн хурдацтай өөрчлөлтийг харгалзан уян хатан байх, жишээ нь, боловсролын зорилго агуулга арга технологи багш үнэлгээ зэрэг цаг үеэ даган өөрчлөгддөг, олон хувилбартай байх шаардлага бий болсон.


Бүх шатны сургуулийн суралцагчид өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэх, мэргэжлийн анхан шатны ойлголттой болох зэрэг хэрэгцээнээс үүдэн сургалтын хөтөлбөрийг сонгон судлах боломжтой байх нь боловсролын бодлого боловсруулахад заавал харгалзах хүчин зүйл болсон.

Дээрх зүйлээс үзвэл, боловсролын бодлогыг орчин үед илүү өргөн хүрээнд, жишээ нь, нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл байдал, хэрэгцээ, тулгамдаж буй үндсэн асуудал зэрэгтэй холбон авч үзэх шаардлагатай болсон.

Орчин үед боловсролын бодлого боловсруулахад харгалзах олон хүчин зүйл бий болсон. Эдгээр нь, гадаад хүчин зүйл бол дэлхийн улс төр, эдийн засгийн хөгжлийн төлөв хандлага, хүний эрх, жендерийн тэгш байдал, экологийн хямрал гэх зэрэг.

Дотоод хүчин зүйл бол Монгол орны өнөөгийн улс төр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, ард түмний уламжлал зан заншил, нийгмийн үнэт зүйл, бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бүлэг давхаргуудын эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын ашиг сонирхол, хүн амын өсөлт гэх зэрэг байна. Үүнийг дараах бүдүүвчээр үзүүлье.

Бүдүүвч №3



Монголын боловсролын бодлогын хөгжилд хийсэн анализ

1995 онд гарсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д боловсролыг *нийгмийн тэргүүлэх салбар* болгон хөгжүүлэх бодлого барьж, түүнийг төрийн ивээл, дэмжлэг, зохицуулалт, нийгмийн хяналтад байлгах, иргэдийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, төрөөс ерөнхий боловсролыг иргэдэд үнэ төлбөргүй олгох зэрэг зүйлийг бодлого болгон баримтална гэж заасан /5,1/. Тус баримт бичигт боловсролын бодлогыг хүнтэй холбож тодорхойлсон санааг бид цаашид гээж болохгүй.

Тухайн үедээ энэхүү бодлогыг хэрэгжүүлэхийн тулд боловсролын тухай шинэ багц хууль, эрх зүйн бусад баримт бичгүүд гарч байсан. Тэр үеэс хойш өнгөрсөн 20-иод жилийн хугацаанд энэхүү бодлого хэр амжилттай хэрэгжсэн эсэхийг эргэн харахад цаашид анхаарч сургамж авах зүйл бас байна. Жишээлбэл, дээр өгүүлсэн боловсролын бодлого нь хэдий хугацаанд ямар үе шаттайгаар хэрэгжих нь тодорхойгүй, тунхаглалын шинжтэй байсан нь алдаа байв. Мөн боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд улс төрийн хүчин зүйл их нөлөөлсний хамт боловсролын бүх шатны байгууллагад ажилладаг хүмүүс, ялангуяа багш нар боловсролын бодлогын мөн чанар, агуулгыг сайн ойлгож чадаагүй зэрэг юм. Иймд боловсролын бодлогыг “төрөөс” буюу дээрээс боловсруулах биш, доороос буюу боловсролын анхан шатны нэгжээс эхлэн тодорхойлж, үүнд нийт багш нарыг оролцуулж, орон нутгийн хөгжлийн хэтийн төлөв, бүс нутгийн хөгжлийн хандлага зэргийг тусган боловсруулбал, хэрэгжих магадлал нэмэгдэнэ.

Монголын боловсролын салбарт сүүлийн 20 жилийн хугацаанд гарсан бодлогын шинжтэй

алдааны нэг бол эрх мэдэл бүхий хүмүүс гадаад улс орнуудаар явж тэдэнд таалагдсан бусдын туршлагыг Монголд шууд хэрэгжүүлэх олон оролдлого хийсэн явдал нь өмнөх тогтолцооны зарим хэсгийг сайжруулах нөлөөтэй байсан боловч үндсэндээ манай орны боловсролын тогтолцоог эвдсэн юм. Ингээд өнөөдрийн монголын боловсрол монгол ч юм шиг үгүй ч юм шиг, америк ч юм шиг эсвэл япон ч юм шиг болсон. Өөрөөр хэлбэл, гадаадын орны сайн туршлагыг “нутагшуулах” хэрэгтэй бөгөөд үүнийг бүтээлчээр хийх нь маш чухал.

Ийм учраас цаашид бид боловсролын салбарт гарч буй асуудлыг шийдэхдээ “гал унтраах” болон “копидох” арга барилаасаа тагталзаж бусдаас бүтээлчээр суралцан 1/ гол асуудлыг сайтар судалж танин мэдэх, 2/ богино, дунд болон урт хугацааны бодлого боловсруулж, тэдгээрийг тууштай хэрэгжүүлэх зорилтууд дэвшүүлэх, 3/ боловсролын салбарт бий болж буй алдаа дутагдал бэрхшээлийг хуримтлуулахгүй, тэр даруйд нь судалж шийдвэрлэх, хөгжлийг тууштай хөтөлж сурах хэрэгтэй боллоо.

Боловсролын бодлогын үр дагавар юу байх вэ?

Боловсролын урт, дунд болон богино хугацааны бодлогын үр дагавар нь 1/ монгол хүний хөгжлийн индекс тодорхой пунктээр ахиж, түүний өрсөлдөх чадвар алхам алхмаар тогтвортой ахих явдал, 2/ монгол улсад ажилгүйдэл, ядуурал буурч, дунд анги төлөвшин бэхжих явдал юм.

Боловсролын бодлоготой холбоотой оюутнуудаас авсан судалгаа, дүгнэлт

Энэ судалгаагаар оюутнууд ЕБС болон мэргэжлийн дээд сургуулиас өөрт хэрэгтэй ямар чадвартай болсон, зах зээлийн нийгэмд ажиллаж амьдрах ямар чадвартай болж байгаа болон ямар чадвар дутаж байгаа, боловсролын салбарын ололт амжилтын талаар тэд ямар төсөөлөлтэй явдаг болон өнөөгийн боловсролын хэрэгцээг юу гэж боддог талаар тэдний санаа бодол, хандлага

зэргийг илрүүлэхийг зорьсон.

Асуулгыг МУБИС, ШУТИС, ЭМШИС, Шихихутаг, Гурван Эрдэнэ, Сутай зэрэг улсын болон хувийн нийт 6 их дээд сургуулийн 3-4-р курсийн 120 оюутнаас /эрэгтэй 60, эмэгтэй 60/ авав. Асуулгыг нэргүй хэлбэрээр авсан. Уг асуулгын бүх асуулт нээлттэй байв.

1/ Дунд сургуулийн сургалт таны амьдралд хэрэгтэй ямар чадвар төлөвшүүлсэн бэ?

Энэ асуултад 120 оюутны өгсөн хариуг дараах чиглэлээр бүлэглэж боловсруулалт хийв.

Үүнд:

- 1/ оюутнууд сурах арга барилтай холбоотой чадварууд эзэмшсэн байдал нь 39,1%-тай,
- 2/ харилцааны чадварууд 20,8%-тай,
- 3/ хүмүүжилтэй холбоотой чадварууд 17,5%-тай,
- 4/ бие даах чадвар 15,8%-тай зэрэг байв.

Эдгээр үзүүлэлт нь 10 гаруй жил суралцаж байж эзэмшиж авсан чадварууд гэхэд тийм ч хангалттай үзүүлэлтүүд биш. Иймд бүх шатны боловсролын бодлого, зорилго нь сурагчдын бие даах чадварыг илүү сайжруулах, тэднийг зөв /сайн/ монгол хүн болгож төлөвшүүлэх, мөн харилцааны зөв чадвар дадалтай болгон төлөвшүүлэхэд чиглэх хэрэгтэй болох нь энэхүү асуултын үзүүлэлтээс харагдаж байна.

2/ Таны сурч буй мэргэжлийн их сургууль таны ажил хөдөлмөрт хэрэгтэй ямар чадвар төлөвшүүлсэн бэ?

Энэ асуултын хариултад боловсруулалт хийхэд:

- 1/ зөв төлөвшил, эерэг хандлагатай холбоотой чадварууд 18,3%-тай,
- 2/ багаар ажиллах чадвар 13,3%-тай,
- 3/ хүмүүстэй зөв харьцах чадварууд 12,5%-тай,
- 4/ мэргэжлийн тусгай чадварууд 11,6%-тай,
- 5/ бие даах чадвар 7,4%-тай зэрэг байна.

Энэхүү асуултад оюутнуудын өгсөн хариуд шинжилгээ хийхэд: 1/түүнд нийт оюутны 63,1% хариулсан бөгөөд үлдсэн 36,9% нь хариулаагүй нь бас нэг зүйл бодоход хүргэж байна.

2/ дунд, дээд боловсролын бодлого, зорилго зэрэгт оюутан сурагчдын бие даах чадварыг хөгжүүлэх, зөв харьцах чадвар төлөвшүүлэх, ер нь зөв төлөвшилттэй болгох зүйлийг тусгах нь зүйтэй.

3/Зах зээлийн нийгэмд ажиллаж амьдрахад хүүхэд залуучуудад ямар чадвар гарцаагүй хэрэгтэй вэ?

Энэ асуултын хариултад боловсруулалт хийхэд:

- 1/ харилцааны соёл 23,3%,
- 2/ зөв төлөвшил, хандлага 20,8%,
- 3/ мэргэжилдээ чадварлаг байх 19,9%,
- 4/ гадаад хэлний чадвар 10,8%,
- 5/ багаар ажиллах чадвар 9,9% зэрэг хариу өгсөн байна.

Эдгээр хариуд шинжилгээ хийж үзвэл: 1/ нийт оюутны 84,7% нь хариу өгсөн нь өмнөх хариултаас дээгүүр үзүүлэлт, 2/ дунд дээд боловсролын бодлого, зорилго зэрэгт оюутан сурагчдад харилцааны соёл, зөв төлөвшил, мэргэжилдээ чадварлаг байх зэрэг зүйлийг тусгах хэрэгтэй нь дээрх хариунуудаас харагдаж байна.

Эхний гурван асуултын хариуг шинжилж үзвэл эдгээрт дараах зүйл давтагдаж байна. Эдгээр нь, зөв төлөвшил, харилцааны соёл, бие даах чадвар. Энэ 3 чадвар давтагдаж байгаа нь эдгээр нь суралцагчдад чухал болохыг харуулж буй учир боловсролын бодлого, зорилго, агуулгыг боловсруулахад заавал тусгаж, сурагчдад төлөвшүүлэх нь зүйтэй болно.

4/ Манай орны дунд дээд боловсролын салбарт таны бодлоор ямар ололт амжилт байна бол?

Энэ асуултын хариултад боловсруулалт хийхэд:

- 1/ зарим зүйл өөрчлөгдөж байна 4,9%,
- 2/ онолын мэдлэг сайн өгдөг 4,1%,
- 3/ цахим орчин бүрдсэн 3,3%,
- 4/ 12 жилийн тогтолцоонд шилжсэн 3,3%,
- 5/ мэргэжлийн төвшинд ажилчин бэлддэг 2,4%,
- 6/ бүх төрлийн мэргэжлээр оюутан бэлддэг 1,6% зэрэг хариу өгсөн байна.

Эдгээр хариу нь асуулгад хамрагдсан нийт оюутны 19,6% бөгөөд үлдсэн 80,4% нь хариу өгөөгүй хоосон зай үлдээсэн байдал нь боловсролын салбарын ололт амжилт манай оюутнуудад тэр бүр сайн харагддаггүй юм болов уу гэсэн сэтгэгдэл төрүүлэхийн хамт магадгүй хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн ололт бага байж ч болох талтай.

5/ Манай орны дунд дээд боловсролын салбарт таны бодлоор ямар дутагдалтай зүйл байна вэ?

Энэ асуултын хариултад боловсруулалт хийхэд:

- 1/ багш нарын мэдлэг чадвар сул 9,1%,
- 2/ авилга хээл хахууль, арын хаалга их 8,3%,
- 3/ сургалтын орчин бүрдээгүй 7,5%,
- 4/ боловсролын чанар тааруу 4,9%,
- 5/ сургалтын төлбөр өндөр 4,1%,
- 6/ чанаргүй олон сургууль байна 3,3% гэх зэрэг хариу өгсөн байна.

Эдгээр хариу нь асуулгад хамрагдсан нийт оюутны 37,2% байгаа ба үлдсэн 62,8% нь үүнд хариу өгөөгүй үлдсэн. Дээрх хариултад хамгийн өндөр үзүүлэлт бол “багш нарын мэдлэг чадвар сул” гэсэн хариу байсан нь зүй ёсоор анхаарал татсан. Үүнд бодлого боловсруулагчид заавал анхаарч арга хэмжээ хэрэгтэй.

6/ Монгол улсын боловсрол орчин үед ямар байх хэрэгтэй гэж та боддог вэ?

Энэ асуултын хариуд боловсруулалт хийхэд орчин үеийн монгол улсын боловсрол нь:

- 1/ дэлхийн түвшинд хүрэх 9,1%,
- 2/ сургалтын орчинг сайжруулах 6,6%,
- 3/ багш нар сайн байх 4,9%,
- 4/ чадварлаг мэргэжилтэн бэлтгэх 4,1%,
- 5/ боловсрол нь цаг үе, монгол хүнд тохирсон байх 2,5% зэрэг хариу өгсөн байна.

Эдгээр хариуд шинжилгээ хийж үзвэл: 1/ хамгийн өндөр үзүүлэлттэй хариу бол “дэлхийн түвшинд хүрэх” гэсэн хариу байгаа нь манай оюутнуудын хэрэгцээ өндөр байгааг харуулж байна. Үүнийг боловсролын бодлогод тусгах нэг чухал санаа гэж үзэж байна,

2/ судалгаанд хамрагдсан нийт оюутны 26,7% энэ асуултад хариу өгсөн байхад үлдсэн 73,3% нь ямар нэг хариу өгөөгүй үлдсэн нь бидний бодох зүйлийн нэг мөн.

Оюутнууд бол боловсролын салбарын гол хэрэглэгчид учраас тэдний санаа бодлыг цаашид боловсролын бодлого боловсруулахад харгалзан үзэж, баримжаа болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Ингээд дээрх судалгааг үндэслэн боловсролын бодлого юуны түрүүнд оюутан сурагчийн хөгжил: зөв төлөвшил, харилцааны соёл, бие даах чадвар зэргийг хөгжүүлэх, мөн багш нарын хөгжил: мэдлэг чадварыг сайжруулах, харилцаа, ёс зүй зэргийг дээшлүүлэх зэрэг рүү чиглэх буюу нэг үгээр хэлбэл, монгол хүний хөгжил рүү тууштай чиглэх хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

Орчин үеийн боловсролын бодлогын тухай зарим санаа

Боловсролын бодлоготой холбоотой заавал тэмдэглэх нэг зүйл бол гол буюу тулгуур үзэл санаа “приоритет” болох зүйлээ эхлээд заавал тодорхойлж, түүнийг тууштай хэрэгжүүлж сурах явдал юм. Тухайлбал, монгол хүний хөгжил, ил тод нээлттэй байдал, тэгш байдал, хүний эрх, шударга ёс, тогтвортой хөгжлийн үзэл санаа зэргийг тулгуур үзлээ болгох нь зүйн хэрэг.

Боловсролын бодлогыг үнэхээр хэрэгжүүлбэ гэвэл нийгмийн хөгжлийн тулгуур үзэл, хууль эрх зүйн үндсийг заавал бодолцох хэрэгтэй. Жишээ нь, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн үзэл санааг сууриа болгох хэрэгтэй.

Ингээд дээр өгүүлсэн зүйлд үндэслэн Монгол улсын боловсролын бодлого нь монгол хүүхэд бүрийг МОНГОЛ ХҮН болгон хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэнэ.

Боловсролын бодлогын дээрх тулгуур санааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үүнийг задалж дараах чиглэлээр авч үзэх нь зүйтэй. Эдгээр нь,

*боловсролын зорилготой холбоотой бодлого

бол монгол хүн бүрийг өөрийн нутагтаа сайн ажиллаж, сайхан амьдрах чадвартай болгож төлөвшүүлэх, суралцагчид бие дааж суралцах арга барилтай, өрсөлдөх чадвартай болох,

*боловсролын агуулгатай холбоотой бодлого бол 1/ сургалтын агуулга монгол үндэсний соёл уламжлалыг өөртөө агуулсан, 2/ нийгмийг бүрдүүлж буй олон хэсэг, бүлэг, давхарга, бүс нутгийн хөгжил зэргийг харгалзан боловсролын агуулга олон хувилбартай байх, 3/ дунд, ахлах ангийн сурагчид авъяас чадавхиа нээн хөгжүүлэх, ирээдүйн мэргэжилтэй холбоотой олон төрлийн хичээл сонгон судлах боломжтой байх, 4/ дэлхийн төвшинд ойртсон зэрэг болно,

*багштай холбоотой боловсролын бодлого бол багш бүрт ажлынхаа байранд тогтвортой хөгжих нөхцөл бүрдүүлэх, харилцааны соёлтой, мэргэжлийн өндөр мэдлэг чадвартай, энэ салбарт хүйсийн тэнцвэрийн харьцааг зохистой болгох зэрэг юм,

*суралцагчидтай холбоотой боловсролын бодлого бол хүүхэд залуус Монгол орныг ирээдүйд авч явах эзэд гэж үзэн хүүхэд бүрт чанартай боловсрол эзэмшүүлэх, тэднийг эх оронч, хөдөлмөрч, бүтээлч, хариуцлагатай, харилцааны соёлтой, бие даах чадвартай иргэн болгон төлөвшүүлэх явдал,

*сургалтыг зохион байгуулахтай холбоотой боловсролын бодлого бол сургалтыг зөвхөн анги танхмийн сургалтаар хязгаарлах бус, хичээлээс гадуур хүүхдийг хөгжүүлэх урлаг уран сайхан, спорт, шинжлэх ухаан танин мэдэхүйн олон төрлийн секц дугуйлан өргөн хичээллүүлэх, боловсролын бүх шатны сургалтад нэг ангид суралцах сурагчийн тоо 30-аас хэтрэхгүй байх бодлогыг хатуу барих явдал,

*сургалтын технологитой холбоотой боловсролын бодлого бол сурагч нэг бүрийн хөгжлийг дэмжсэн, сурагчийн оролцоонд тулгуурласан сурагч төвтэй сургалтын арга технологийг бүтээлчээр хэрэгжүүлэх, сурагч болгон мэдлэг бүтээгч байх явдал,

*үнэлгээтэй холбоотой боловсролын бодлого бол сурагчдын мэдлэг чадвар төлөвшил хөгжил зэргийг дэмжсэн чанарын үнэлгээг гол болгох, сурагчийн өөрийн үнэлгээг хөгжүүлэх зэрэг байна.

Дээрх зүйлээс гадна боловсролын бодлого нь боловсролын шатлалтай холбоотойгоор:

*сургуулийн өмнөх боловсролын бодлого бол хүүхэд бүрийг суурь сайн хүмүүжилтэй болгон төлөвшүүлэх,

*бага боловсролын бодлого бол хүүхэд болгон

монгол хэлээр ярих, алдаагүй бичих, чөлөөтэй унших, бие дааж сэтгэн бодох, тоог 4 үйлдлээр бодох, бие дааж суралцах арга барил эзэмшүүлэх, байгаль орчноо хайрлах, бусадтай боловсон харилцах, эх орноо гэсэн хүмүүжилтэй болгох,

*суурь боловсролын бодлого бол сурагчдыг харилцааны зөв чадвар дадалтай болгох, тэдэнд бие даан амьдрах, хөдөлмөрлөх арга ухаан төлөвшүүлэх,

*ерөнхий боловсролын бодлого бол сурагч цааш үргэлжлүүлэн амжилттай суралцах, хөдөлмөрлөх суурьтай болгох,

*мэргэжлийн боловсролын бодлого бол зах зээлийн нийгэмд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн төлөвшүүлэх зэрэг байж болно.

Эдгээр бодлогыг боловсролын салбар дангаараа шийдвэрлэж чадахгүй учир бусад салбартай юун дээр хамтрах шаардлагатайг заавал тодорхой болгоно.

ДҮГНЭЛТ

Боловсролын бодлого нь монгол хүний хөгжлийг дэмжихэд чиглэнэ,

Боловсролын бодлогыг бүх нийтийн хүртээл болгон сурталчлах, бүх нийтээр хэрэгжүүлэх,

Боловсролын бодлогыг боловсролын бүх шатанд тууштай хэрэгжүүлэх механизм бий болгон хэрэгжүүлэх нь чухал байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Боловсролын бодлого, төлөвлөлт, удирдлага. (2012). *ЮНЕСКО-ийн сургалтын материал*. Улаанбаатар

Монгол Улсын Их Хурал. (2006). Боловсролын тухай хууль. Улаанбаатар

Гита Стайнер-Хамси, Инес Штольпе. (2007). *Боловсролын бодлогын импорт. Даяар шинэчлэл ба Монголын орон нутгийн хүчин зүйл*. Хянан тохиолдуулсан А.Гэрэлмаа, Б.Жадамбаа, Ц.Гомбосүрэн. Улаанбаатар

Ичинхорлоо, Ш. Мандах, Д. (2013). *Боловсролын социологийн удиртгал*. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (1995). *Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого*. Улаанбаатар

Монгол Улсын Их Хурал. (2014). *Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /төсөл/*. Улаанбаатар

"Шинэ зууны багшийн чадамж".
эмхэтгэл. 2014